

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

“Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай”  
хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль  
2020.12.31

Дагаж мөрдөх огноо:

.. 21 03 09

Албан тушаалын тодорхойлолтыг  
баталсан огноо:

.. 21 03 05

Байгууллагын нэр:

Гадаадын иргэн, харьяатын газар

Нэгжийн нэр:

Зөрчил шалган шийдвэрлэх газар

/Төрийн албаны зөвлөлийн 2021.03.03-ны 74 дүгээр тогтоолоор  
өөрчлөлт орсон/

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Хяналт шалгалт хариуцсан хяналтын  
улсын ахлах байцаагч  
/Төрийн албаны зөвлөлийн 2021.03.03-ны 74 дүгээр  
тогтоолоор өөрчлөлт орсон/

Дэс түшмэл, Т3-8

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа дэнж, Гадаадын  
иргэн, харьяатын газрын төв байр

Хөдөлмөрийн нэхцэл:

Онцгой нэхцэл:

Хэвийн

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын стратеги төлөвлөгөө, зорилт чиг үүргийн хүрээнд гадаадын иргэний талаарх болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналтын улсын байцаагч нарын үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцсан чиг үүргийн хүрээнд удирдлагыг мэргэшил арга зүй, бодит мэдээ, мэдээллээр хангах, үр дүнг даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих.
2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн асуудлыг шийдвэрлэх.
3. Монгол Улсаас албадан гаргасан, гарах эрхийг түр түдгэлзүүлсэн, түр саатуулсан гадаадын иргэн болон зөрчил гаргасан хүн, хуулийн этгээдийн талаарх мэдээллийн сангүнэн зөв бүрдүүлэх, баяжуулах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чигүүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамж боловсруулах зохион байгуулах, дүнг нэгтгэн байгууллагын удирдлагад танилцуулах;</p> <p>2. Зөрчил гаргасан хүн, хуулийн этгээдэд зөрчил арилгуулах талаар албан шаардлага, гарах сануулга өгөх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>3. Монгол Улсад цагаачлан болон гэр бүлийн шалтгаанаар, түүнчлэн шаардлагатай бусад хэлбэрээр оршин суух хүсэлт гаргасан гадаадын иргэний ахуй нөхцөлийг тогтоох зорилгоор хяналт шалгалт хийх, зохион байгуулах, дүгнэлт гаргах ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах, удирдах; /Төрийн албаны зөвлөлийн 2021.03.03-ны 74 дүгээр тогтоогоор өөрчлөлт орсон/</p> <p>4. Гадаад улсын болон олон улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газрын үйл</p>	<p>Хуулийн хэрэгжилтэд хяналт тавьсан байна.</p> <p>Хяналт шалгалтын ажиллагаа хийгдсэн байна.</p> <p>Хяналт шалгалтыг хуулийн хүрээнд зохион байгуулсан байна.</p> <p>Хяналт шалгалтыг хуулийн хүрээнд зохион байгуулсан байна.</p>	<p>Г, Х</p> <p>Г, Х</p> <p>Г, Х</p> <p>Г, Х</p>



	ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор хяналт шалгалт хийх, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах, удирдах; Төрийн албаны зөвлөлийн 2021.03.03-ны 74 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/		
	5.Холбогдох тайлан, мэдээ, судалгааг дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Тайлан, мэдээ, судалгааг холбогдох газар, нэгжид хугацаанд нь хүргүүлсэн байна.	Г
	1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийг зөрчсөн уригч, гадаадын иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг шийдвэрлэх;	Хүн, хуулийн этгээдийг гаргасан зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.	Г, Х
	2.Хуульд заасан үндэслэлээр гадаадын иргэнийг saatuuлах ажиллагаа, баримт бичгийн бүрдэлд хяналт тавих;	Баримт бичгийг журмын дагуу бүрдүүлсэн байна.	Х
2 дугаар зорилтын хүрээнд	3.Хяналтын улсын байцаагчийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;	Зөрчлийн шийдвэрлэлтэд хяналт тавигдсан байна.	Х, Ш
	4.Хяналтын улсын байцаагчийн гадаадын иргэнийг албадан гаргах тухай дүгнэлтийн эрх зүйн үндэслэл, албадан гаргах ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих;	Албадан ажиллагаанд хяналт тавигдсан байна.	Г, Х
	5.Хяналтын улсын байцаагчийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.	Хяналтын улсын байцаагчийн ажиллагаанд хяналт тавигдсан байна.	Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Зөрчил гаргасан хүн, хуулийн этгээдийн талаарх мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд үнэн зөв бүртгэх, баяжилт хийх, хяналтын улсын байцаагчийн бүртгэл, баяжилтад хяналт тавих;	Мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлтэд хяналт тавигдсан байна.	Г, Х
	2.Монгол Улсаас албадан гаргасан, гарах эрхийг түр түдгэлзүүлсэн гадаадын иргэний	Мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлтэд хяналт тавигдсан байна.	Г, Х



	мэдээллийг мэдээллийн санд бүртгэх, хяналт тавих;		
	3.Хариуцсан нутаг дэвсгэр дэх объектын судалгаа, бүртгэлд хяналт тавих.	Объектын бүртгэл судалгааны баяжилтад хяналт тавигдсан байна.	Г, Х
Бусад үйл ажиллагаа	1.Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Захиргааны өрөнхий, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Монгол Улсын хилийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Архивын тухай, Нийтийн албанд, нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам” болон бусад хуульд тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;	Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	Г
	2.Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гарсан тохиолдолд хариуцлага хүлээх;	Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.	Г
	3.Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гарсан тохиолдолд хариуцлага хүлээх;	Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөн зөрчил, дутагдал гаргалгүй ажилласан байна.	Г
	4.Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх;	Үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж ажилласан байна.	Г
	5.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, чиг үүргийн хүрээнд баримт бичиг боловсруулах, холбогдох байгууллагад хүргүүлэх;	Албан бичгийг хугацаанд нь хуулийн дагуу, үндэслэлтэй шийдвэрлэсэн байна.	Г
	6.Байгууллагатай харилцах үйлчлүүлэгчдэд хариуцсан зөвлөгөө, мэдээллийг үнэн зөв хүргэх;	Мэдээлэл, зөвлөгөө нь хуульд нийцсэн үнэн бодитой байна.	Г



	7.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх;	Өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Г
	8.Хариуцсан ажлын чиглэлээр боловсруулан гаргасан албан бичгийг стандартын дагуу цэгцэлж, байгууллагын архивд хүлээлгэн өгөх;	Архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн стандартыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан байна.	Г
	9.Төрийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гарган холбогдох мэргэжилтэнд өгөх;	Нэгжийн үйл ажиллагаанд уялдуулан төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнасан байна.	Г
	10.Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох.	Арга хэмжээнд оролцсон байна.	Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	- эрх зүй /042/; - олон улсын харилцаа;		
Мэргэшил	төрийн захиргааны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байх. //Төрийн албаны зөвлөлийн 2021.03.03-ны 74 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/		
Туршлага	туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. //Төрийн албаны зөвлөлийн 2021.03.03-ны 74 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлاغнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, үр дагаврыг хариуцах, үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.	
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бусдыг дэмжих, хамтран ажиллах; - бусадтай харилцаан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьслалтыг дэмждэг байх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах;	



		- бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах;</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэй аргыг ашиглах;</li> <li>- бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах;</li> <li>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;</li> </ul>

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Гадаадын иргэн, харьяатын газрын Дарга, Дэд дарга, Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга.

Албан тушаалд шууд харьялан  
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Хяналтын улсын байцаагч  
Мэргэжилтэн

Нийт:

Бусад харилцах субъект

- 1.Яам, агентлаг, тэдгээрийн ажлын албаны холбогдох албан тушаалтан;
- 2.Гадаад орон, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага;
- 3.Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг  
боловсруулсан:

Албан тушаал:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА  
..... Д.ДАВААНЯМ  
2021 оны ..... дугаар сарын ..... -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг  
хянаж, батлах зөвшөөрөл олгосон  
байгууллагын шийдвэр:

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 21 03 03

Дугаар: 74

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар: A/44

(тамга/тэмдэг)

Агентлагийн дарга

N.УУГАНБАЯР

